

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.08

Онцлох мэдээ

- Япон улсад хэрэглэгчийн эрэлт сул хэвээр байсаар өрхийн хэрэглээ нь жилийн байдлаар 5 дахь сардаа дараалан буурчээ. 12-р сард өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.2% буурсан нь 0.3% өснө гэсэн зах зээлийн таамаглалаас бага байв.
- АНУ болон Япон улсууд Трампын үед Япон улсаас жилд 1.25 орчим сая тонн ган импортлоход тавигдсан тарифыг цуцлах талаар хэлэлцээр хийж байгаагаа Даваа гарагт мэдэгдлээ. Вашингтоноос өнгөрсөн жилд үүнтэй ижил төстэй боломжийг Европын Холбооны ган үйлдвэрлэгчдэд олгоод байсан юм.

Валютын зах зээл

Эргэн өсөж байсан еврогийн ханш хүчтэй эсэргүүцлийн түвшинд хүрч чадаагүй байгаа ба арилжаачид ам.долларын ханшийг чангаруулж мэдэх АНУ-ын инфляцийн тоон мэдээг хүлээж байна. Европын төв банк бодлогоо чангатгах дохио өгсний дараа еврогийн ханш өнгөрсөн долоо хоногт 2.7% чангарсан. Энэхүү өсөлтөө барьж байгаа хэдий ч эсэргүүцлийн 1.1483 түвшнийг давж чадаагүй байна. Азийн зах зээлийн эхэн үеийн арилжаагаар ам.долларын иений эсрэг 0.1% сайжирч 115.22 хүрсэн бол ам.долларын индекс 95.425 орчимд эргэлдэж байна. Фунт стерлинг 1.3538-д тогтуун арилжаалагдлаа. Австрали доллар 0.7% өсөж 0.713 хүрснээр 50 өдрийн дундаж 0.7163-ийн эсэргүүцлийн түвшний доохон тогтов.

Алтны зах зээл

Мягмар гарагт алтны ханш тогтвортой харагдаж байна. Зах зээлд оролцогчид АНУ-ын Холбооны Нөөцийн банкны дэмжлэгээ бууруулах төлөвлөгөөний хуваарьт чухал инфляцийн мэдээ хүлээх зуур инфляцийн дарамт эрсдэл багатай металлын эрэлтийг хэвээр барьж ханшийг нь нэг долоо хоногийн дээд түвшинд тогтворжуулсаар байна. 1 унц алтны спот ханш Даваа гарагт хүрсэн дээд үнэ 1,823.21 гэсэн цэгтэй ойрхон 1,821.26 ам.доллар дээр байна. АНУ-ын алтны фьючерс GCv1 өглөө 1,821.30 ам.доллартай тэнцүү байлаа.

Зэсийн зах зээл

Хятадын Байсе хотод коронавирусын хязгаарлалт хөнгөн цагааны тээвэрлэлтэд нөлөөлснөөр Лондонгийн хөнгөн цагааны үнэ 4 сарын дээд цэгт хүрсэн бол зэсийн үнэ мөн өслөө. Лондонгийн Металлын Биржийн хөнгөн цагааны фьючерс 1.2% дээшилж 3,170 ам.доллар, зэсийн фьючерс 0.4% өсөж 9,812 ам.доллар тус тус болов. Шанхайн Фьючерсийн биржийн зэс 0.3% буурч тонн нь 70,620 юаньтай тэнцлээ. Чили улсын зэсийн экспортын орлого 1-р сард 3.87 тэрбум ам.доллар хүрснийг төв банкнаас нь мэдээллээ.

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1431	-0.10%		
USD/CNY	6.3615	-0.05%		
USD/RUB	75.5062	0.01%		
USD/JPY	115.38	0.24%		
USD/KRW	1197.85	-0.21%		
AUD/USD	0.7133	0.03%		
GBP/USD	1.3529	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	35091.1	0.00%		
S&P 500	4483.9	-0.37%		
NASDAQ	14015.7	-0.58%		
FTSE 100	7573.5	0.76%		
Nikkei 225	27347.1	0.36%		
DAX	15206.6	0.71%		
Hang Seng	24426.7	-0.62%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1823.06	0.14%		
Мөнгө	22.99	-0.12%		
Нүүрс (Чин хуанг дао)	153.58	0.00%		
Зэс (LME)	9777.5	-0.65%		
Төмрийн хүдэр	833.00	2.52%		
Газрын тос (NYME)	91.1	-0.24%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.12%	3.59%		
US 3M LIBOR	0.34%	7.62%		
US 6M LIBOR	0.56%	5.05%		
US 12M LIBOR	1.00%	5.84%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.93%	0.85%		
UK Treasury 10Y	1.41%	-0.21%		
GE Treasury 10Y	0.23%	11.22%		
JP Treasury 10Y	0.21%	4.06%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.08%	-0.03%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.71%	-0.10%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.09%	-0.30%
Хуралдай	8.75%	3/9/2024	4.04%	-0.02%
ММС	9.25%	4/15/2024	22.31%	-0.38%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.15%	-0.01%
Номад	5.13%	4/7/2026	4.78%	-0.07%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.95%	-0.03%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.39%	-0.11%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	-0.01%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	19.17	3.12%
Mongolian Mining Corp	1.78	1.71%
Erdene Resource Dev	0.39	1.32%
Centerra Gold	10.58	2.12%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд					
Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
CN Caixin Services PMI	51.4	-	53.1
GE Industrial Output MM	-0.3%	0.4%	-0.2%
UK Hailfax House Prices MM	0.3%	-	1.1%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
CA Trade Balance C\$	21:30	2.62B	3.13B
US International Trade \$	21:30	-83.0B	-80.2B
JP Current Account NSA JPY	7:50	73.5B	897.3B

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US Wholesale Invt, R MM	23:00	2.1%	2.1%
GE Trade Balance EUR	15:00	10.4B	10.9B
IT Industrial Output YY	17:00	5.0%	6.3%
IT Industrial Output MM	17:00	-0.7%	1.9%

Газрын тосны зах зээл

АНУ-аас Иран улсын газрын тосны борлуулалтад тавьсан хоригийг цуцлах, хөнгөрүүлэх талаар яриа 10 хоног завсарлаад эхэлсэн байна. Тус хэлэлцээр газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүлээлт үүсгэж үнэ бага зэрэг суларч байна. АНУ-аас хоригийг хэсэгчлэн буулгах саналтай байгаа бол Иран улсын зүгээс хоригийг бүрэн цуцлах, цаашид дахин хориг тавихгүй байх тал дээр тохиролцоо саналтай байна. Brent газрын тосны үнэ 36 цент унаж 92.33 ам.долларт арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

АНУ-ын 1-р сарын ажлын байрны мэдээ төсөөлснөөс сайн гарч Баасан гарагт өсөөд байсан 10 жилийн хугацаатай засгийн бондын өгөөж Даваа гарагт буурчээ. Өнгөрсөн долоо хоногт өгөөж нь 14 суурь нэгжээр өссөн бол Даваа гарагт 1.4 суурь нэгж буурч 1.918% болов.

Хөрөнгийн зах зээл

Японд хувьцаа өсөлттэй байгаа бол БНХАУ уналттай байна. АНУ-ын хөрөнгийн зах зээл савлагаа өндөртэй байж уналттай хаагдсан байна. Технологийн компаниудын хувьцааны үнэ уналтад гол нөлөөлсөн байна. Хөрөнгө оруулагчид Пүрэв гарагт зарлагдах АНУ-ын инфляцийн мэдээг хүлээж байна. Тус мэдээ дараагийн мөнгөний бодлогын шийдвэрт чухал нөлөөтэй. Гэхдээ "АХА" хөрөнгө оруулалтын сангаас мөнгөний хатуу бодлогоос гадна компаниудын орлого, ашгийн хөдөлгөөн хөрөнгийн зах зээлд чухал гэж хэлсэн байна.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харууллага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мэйлд харуу илгээнэ үү.